



ҮНДЭСНИЙ
АУДИТЫН
ГАЗАР

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Аудитын нэр: Ноён сумын ИТХ-ын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийх

Аудитын код: ОМА-2025/76-ШТА-НА

**УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ХӨРӨНГИЙГ ЗОРИУЛАЛТЫН
ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА.**

Цахим хуудас
www.audit.mn

ДАЛАНЗАДГАД ХОТ
2025 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор: Т.Өсөхбаяр
Утас: 70533552
Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn
Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас: 70533552
Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn
Аудитор: А.Ганзуузай
Утас: 70533552
Цахим хаяг: Ganzuuzai@audit.gov.mn
Аудитор: Э.Жамцдорж
Утас: 70533552
Цахим хаяг: JamtsdorjE@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	3
Ерөнхий мэдээлэл	4
Бүлэг 1. Ноён сумын ИТХ-ын нөхөн сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн хөрөнгийг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан байна.....	
1.1. Сонгуулийн хороонд төсвийг үндэслэлтэй хуваарилсан байна.....	
1.2. Сонгуулийн хэсгийн хороонд төсвийг үндэслэлтэй хуваарилсан байна.....	
Бүлэг 2. Ноён сумын ИТХ -ын нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй зарцуулсан байна.....	
2.1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу, арвилан хэмнэлттэй зарцуулсан байна.....	
2.2. Өмнөх албан шаардлагыг хэрэгжүүлж ажилласан байна.....	
ДҮГНЭЛТ	13
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ.....	14
ТАЙЛАНГИЙН БАТАЛГААЖУУЛАЛТ	15

■ ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
АСХ	Аймгийн сонгуулийн хороо
ШТА	Шууд тайлагнах аудит

ХҮСНЭГТИЙН ТОВЬЁГ

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	АСХ-ы батлагдсан төсөв зардлын ангилал	6
2	АСХ-оос Ноён сумын сонгуулийн хороонд хуваарилсан төсөв	6
5	АСХ, сумдын сонгуулийн хорооны төсвийн хэмнэлт	7
6	Аймаг, сумдын сонгуулийн хорооны батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэл зардлын ангилал	7

ДҮРСЛЭЛИЙН ТОВЬЁГ

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	АСХ болон Ноён сумын сонгуулийн хороодын төсвийн гүйцэтгэлийн харьцуулалт	5

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2024 оны А/108, 2025 оны А/44 дүгээр тушаалыг тус тус үндэслэн “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэл”-д аудит хийж гүйцэтгэлээ.
Аудитын зорилт	Ноён сумын ИТХ-ын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан аудитын тайланг АСХ болон Ноён сумын сонгуулийн хороо танилцуулж, бусад байгууллага, иргэд, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ. Энэхүү зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: • ИТХ-ын нөхөн сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх, • ИТХ-ын нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх.
Аудитын хамарсан хүрээ	Аудитад АСХ, Ноён сумын сонгуулийн хороог хамрууллаа.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 400, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт Нийцлийн аудит MNS 6817:2020, Нийцлийн болон Санхүүгийн аудитын арга зүйг ашиглан улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын талаар холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан, судалгаа, хөтөлбөр, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр удирдаж, үе шатны болон чанарын хяналтыг аудитын менежер Т.Хонгорзул, ахлах аудитор Г.Шижиболд нар хэрэгжүүлж, аудитор Э.Жамцдорж хийж гүйцэтгэлээ. Аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг 2025 оны 07 дугаар сарын 28-наас 8 дугаар сарын 05-ны өдрийн хооронд хэрэгжүүлж, талбарын үе шатны ажлыг аймаг дахь Төрийн аудитын газар 2025 оны 08 дугаар сарын 06-ны өдрөөс эхлүүлж, тайлан, судалгаа, зөрчлийн бүртгэлийг 2025 оны 08 сарын 15-ны өдрийн дотор хүргүүлэв.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсэг /Орон нутгийн Хурлын нөхөн сонгуулийг тухайн аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн нөхцөл байдал үүссэнээс хойш 60 хоногт багтаан товлон зарлана./-т зааснаар Ноён сумын ИТХ-ын 2025 оны 3/01 дүгээр тогтоолоор нөхөн сонгуулийг товлон зарласан байна.

Тус хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт зааснаар аймгийн ИТХ-ын 2025 оны 5/26 дугаар тогтоолоор аймгийн Сонгуулийн хороог, 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэгт зааснаар Ноён сумын ИТХ-ын 2025 оны 03/02 дугаар тогтоолоор сумын Сонгуулийн хороог, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт зааснаар сумын Сонгуулийн хорооны 2025 оны 03 дугаар тогтоолоор хэсгийн хороог тус тус байгуулж, нөхөн сонгуулийг зохион байгуулж явуулсан байна.


Орон нутгийн хурлын нөхөн сонгуулиар Өмнөговь аймгийн Ноён сумын 2 дугаар тойрогт сонгогчдын нэрсийн жагсаалтад 392 сонгогч бүртгэлтэй байснаас 249 иргэн буюу 63.52 хувь нь саналаа өгсөн байна.

Ноён сумын ИТХ-ын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулахад аймгийн Сонгуулийн хороо 7, сумын Сонгуулийн хороо 5, хэсгийн хороо 7, мэдээлэл технологийн баг 2, цагдаагийн албан хаагч 2, улсын бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтан 2, жолооч 1, нийт 26 албан хаагч ажилласан байна.

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн “Аймаг, нийслэлийн сонгуулийн зардлын төсвийн хуваарь батлах тухай” А/18 дугаар тушаалын хавсралтаар аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгуулийн Өмнөговь аймгийн сонгуулийн хорооны төсвийг 36,969,600 /гучин зургаан сая есөн зуун жаран есөн мянга зургаан зуун/ төгрөг байхаар баталсан байна.

Өмнөговь аймгийн сонгуулийн хороо нь батлагдсан төсвөөс 35,315,400 /гучин таван сая гурван зуун арван таван мянга дөрвөн зуун/ төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулж, 1,654,200 төгрөгийг СЕХ-ны дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

.График 1.АСХ болон Ноён сумын сонгуулийн хороодын төсвийн гүйцэтгэлийн харьцуулалт



Эх сурвалж: Аудитын судалгаа

БҮЛЭГ 1. УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ХӨРӨНГИЙГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ, ХУВААРИЛСАН БАЙНА.

1.1. Улсын төсвөөс олгох хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг бодитой тооцсон байна.

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын даргын 2025 оны А/18 дугаартай тушаалаар ИТХ-ын 2025 оны нөхөн сонгуулийн Өмнөговь АСХ-ны төсвийг 36,969,600 төгрөгөөр төсөвлөж баталсан байна.

Хүснэгт 1. АСХ-ы батлагдсан төсөв зардлын ангиллаар.

/төгрөгөөр/

№	Зардлын нэр	Төсөв
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	77,000
2	Сургалтын зардал	1,425,000
3	Бичиг хэрэг	450,000
4	Шуудан холбоо	700,000
5	Унааны зардал	1,360,000
6	Санал авах байр бэлтгэх зардал	300,000
7	Сурталчилгааны зардал	700,000
8	Саналын хуудас, төхөөрөмжийн авах, хүргэх зардал	5,560,000
9	МТБ-ийн гишүүний холбоо, унааны зардал	500,000
10	Эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх	140,000
11	Сонгуулийн хороодын урамшуулал, хоолны зардал	17,852,800
12	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал	3,404,800
13	Томилолтын зардал	2,780,000
14	Шуурхай багийн зардал	1,720,000
	Нийт дүн	36,969,600

Эх сурвалж: СЕХ-ны Тамгын газрын даргын 2025 оны А/18 дугаар тушаал

Монгол Улсын СЕХ-ны 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдийн А/17 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-д заасны дагуу төсвийг АСХ-нд хуваарилсан байна.

Мөн АСХ-нд СЕХ-ны Тамгын газрын даргын 2025 оны 3/230, 3/285 тоот албан бичгүүдээр санхүүжилтийн хуваарийн тайлбар, сумын сонгуулийн хороонд зардлыг хэрхэн хуваарилах талаар тодорхой чиглэл өгсөн байна.

1.2. Сонгуулийн хороонд төсвийг үндэслэлтэй хуваарилсан байна.

АСХ-ны даргын 2025 оны 03 дугаар захирамжаар 16,100,400 төгрөгийг Ноён сумын сонгуулийн хороонд Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий хорооны даргын 2025 оны А/18 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын дагуу тооцож хуваарилсан байна.

Хүснэгт 2. АСХ-оос Ноён сумын сонгуулийн хороонд хуваарилсан төсөв.

/төгрөгөөр/

№	Зардлын нэр	Төсөв
1	Бичиг хэрэг	150,000
2	Шуудан холбоо	200,000
3	Унааны зардал	960,000
4	Санал авах байр бэлтгэх зардал	300,000
5	Сурталчилгааны зардал	700,000
6	Саналын хуудас, төхөөрөмжийн авах, хүргэх зардал	1,320,000
7	Эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх	140,00

8	Сонгуулийн хороодын урамшуулал, хоолны зардал	10,035,200
9	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал	1,635,200
10	Томилолтын зардал	660,000
	Нийт дүн	16,100,400

Эх сурвалж: Өмнөговь АСХны даргын 2025 оны 03 дугаар захирамж

Аймгийн сонгуулийн хороо нь СЕХ-с ирүүлсэн аймаг нийслэлийн сонгуулийн хорооны төсвийн зарцуулалтын тухай тайлбарт заасан газар нутгийн байршил, сумын сонгуулийн хороо, хэсгийн хороодын тоо, түүнд ажиллах хүний тоо зэрэг тодорхой мэдээллүүд дээр тулгуурлан тооцож төсвийг үндэслэлтэй хуваарилсан байна..

БҮЛЭГ 2. УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА.

2.1 Батлагдсан төсвөөс 1,654,200 төгрөгийг хэмнэж ажилласан байна.

Аудитаар АСХ, Ноён сумын сонгуулийн хорооны төсвийн гүйцэтгэлийг тайланг анхан шатны баримт, төрийн сангийн дансны хуулгатай тулган батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан эсэхийг шалгахад зохих эдийн засгийн ангиллын дагуу зарцуулсан байна.

Хүснэгт 5. АСХ болон Ноён сумын сонгуулийн хорооны төсвийн хэмнэлт /төгрөгөөр/

№	Сонгуулийн хорооны нэр	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Хэмнэлт
1	АСХ	20,869,200	19,906,100	963,100
2	Ноён сум	16,100,400	15,409,300	691,100
	Нийт дүн	36,969,600	35,315,400	1,654,200

Эх сурвалж: Аудитын судалгаа.

Дээрх хүснэгтээс харахад АСХ болон Ноён сумын сумын сонгуулийн хороонд нийт 1,654,200 төгрөгийг хэмнэж ажилласан байна.

Хүснэгт 6. Аймаг, сумдын сонгуулийн хорооны батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэл зардлын ангиллаар. /төгрөгөөр/

№	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Хэмнэлт
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	77,000	77,000	-
2	Сургалтын зардал	1,425,000	1,425,000	-
3	Бичиг хэрэг	450,000	450,000	-
4	Шуудан холбоо	700,000	636,300	63,700
5	Унааны зардал	1,360,000	825,500	534,500
6	Санал авах байр бэлтгэх зардал	300,000	300,000	-
7	Сурталчилгааны зардал	700,000	700,000	-
8	Саналын хуудас, төхөөрөмжийн авах, хүргэх зардал	5,560,000	5,560,000	-
9	МТБ-ийн гишүүний холбоо, унааны зардал	500,000	500,000	-
10	Эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх	140,000	0	140,000
11	Сонгуулийн хороодын урамшуулал, хоолны зардал	17,852,800	16,936,800	916,000
12	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал	3,404,800	3,404,800	-
13	Томилолтын зардал	2,780,000	2,780,000	-
14	Шуурхай багийн зардал	1,720,000	1,720,000	-
	НИЙТ ДҮН	36,969,600	35,315,400	1,654,200

Эх сурвалж: Аудитын судалгаа

АСХ болон Ноён сумын сонгуулийн хороо нь шуудан холбооны зардал, унааны зардал, эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх зардал, сонгуулийн хороодын урамшуулал болон хоолны зардлаас нийт 1,654,200 төгрөгийг хэмнэсэн байна.

2.2. Өмнөх албан шаардлагыг хэрэгжүүлж ажилласан байна.

2024 оны УИХ-ын ээлжит сонгуулийг зохион байгуулахтай холбогдуулан улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд хийсэн аудитаар автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахууны жишиг нормыг хэтрүүлж 1,058,900 төгрөгийн шатахуун зарцуулсан зөрчлийг арилган, Зам, тээврийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 390 дугаар журмыг хэрэгжүүлсэн байна.

Тус албан шаардлагын хэрэгжилтийг 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 02/396 дугаар тоотойр Өмнөговь аймаг дахь төрийн аудитын газарт хүргүүлсэн байна.

2.3 Зарим санхүүгийн баримт, тайланг холбогдох журмын дагуу баталгаажуулаагүй байна.

АСХ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Засгийн газрын 2024 оны 214 дүгээр тогтоолоор баталсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын 8.1.3 дахь заалтын дагуу санхүүгийн баримт, тайланг баталгаажуулаагүй байна.

ДҮГНЭЛТ:

Аудит хийх явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Улсын төсвөөс олгох хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг бодитой тооцсон байна.
2. Сонгуулийн хороодод төсвийг үндэслэлтэй хуваарилсан байна.
3. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.
4. Зардлын тайланг бодитой тайлагнасан байна.
5. Сонгуулийн зардлын зарцуулалтад хяналт хэрэгжүүлсэн байна.



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 08 сарын 19 өдөр


Дугаар А/23

Даланзадгад сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9-д, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны А/102 дугаар "Эрх шилжүүлэх тухай" тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1.4-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Ноён сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийх" нийцлийн аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Нийцлийн аудитын газар болон Өмнөговь аймгийн сонгуулийн хороо, Ноён сумын сонгуулийн хороонд тус тус хүргүүлэхийг ахлах аудитор (Г.Шижирболд)-т үүрэг болгосугай.
3. Аудиттай холбоотой ажлын нотлох баримтыг архивын нэгж болгон хүлээлгэн өгөхийг аудитор (Э.Жамцдорж)-т даалгасугай.



Ц.ӨСӨХБАЯР

4625010066



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2025.08.19 № 426
танай _____-ны № _____-т

┌ АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРООНЫ ┐ ДАРГА Ц.АМАРТӨГС ТАНАА

Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн "Ноён сумын ИТХ-ын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийх" нийцлийн аудитын тайланг хүргүүлж байна.

Хавсралт....хуудастай



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ӨСӨХБАЯР